

ТӨРӨӨС ЭРҮҮЛ МЭНДИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫГ 2018 ОНД

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

2018.11.17

Д/д	Үйл ажиллагааны нэр	Бүтээгдэхүүн	Хэрэгжилт
1. НЭМ-ийн тусламж үйлчилгээг сайжруулах, чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.			
1.1	Эрүүл мэндийг дэмжих сурталчлах замаар хүн амын боловсролыг дээшлүүлж, өвчлөлөөс урьдчилан сэргийлнэ.		
2. Эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулна.			
2.1.	Эмнэлгийн тусламж үйлчилгээнд үйлчлүүлэгчид ээлтэй байдлыг бүрдүүлэх магадлан итгэмжлэл бүхий салбарыг хөгжүүлэх		<p>Эх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлсэн албан байгууллага шалгаруулах болзолт уралдааныг ЭМДэмжигч байгууллагын туг аялуулах болзолд тусган хэрэгжүүлж байна. Өрхийн 3 ЭМТ-д эх, хүүхдийн тусламж үйлчилгээний бэлэн байдлаар хяналт үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлсэн. БОЭТ-ийн бүх тасаг нэгжээр 2 удаа зөвлөн туслах, хяналт үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилт 80%-тай. Жирэмсэн эмэгтэйчүүдийн эрт үеийн хяналтаар эмнэлгүүдийн 50%-д нь ажлын байран дахь хяналт үнэлгээ хийж, 100% дотоодын үнэлгээ хийлгэж, дүгнэлт, зөвлөмжөөр хангаж, давхардсан тоогоор 3 удаа 21 эмнэлэгт зөвлөмж өгч, хэрэгжилт 78%-тай байна. Хүүхдийн эндэгдэлтэй Баян-Овоо суманд 10 сард, өмнө нь Ханбогд, Булган, Хүрмэн сумдад зөвлөн туслах баг хяналт үнэлгээ хийж, газар дээр нь зөвлөмж өгсөн. Эх барихын арга зүйч ажиллуулж төрөх тохиолдол бүрт НЭҮНШТҮ-г нэвтрүүлэн, хяналт үнэлгээг тогтмолжуулж, жирэмсний дасгал, сургалтын чанарыг сайжруулсан. Эх яагаад эндэв, хүүхэд яагаад эндэв зөвлөмжийн дагуу ЭМГ-ын даргын А/59 тушаал гаргуулж, хяналтын хуудсаар дотоодын үнэлгээ хийж, хэлэлцүүлэг зохион байгуулсан. Үнэлгээ дунджаар 75% байсан ба 18 анхан шатны эмнэлэг үйл ажиллагаандаа дүгнэлт хийсэн. Эмнэлгүүдэд 5 эмнэлгийг магадлан итгэмжлэлд, 4 эмнэлгийг тусгай зөвшөөрөлд хангалттай үзүүлэлтээр үнэлүүлсэн. Өрхийн эмнэлгүүдтэй гүйцэтгэлийн гэрээ байгуулан ажиллаж, 6 удаагийн мэргэжлийн зөвлөмж өгч ажиллан, гэрээний биелэлт 70% хэрэгжиж байна. Багаж тоног төхөөрөмж, түргэний машины хангалт 95%-аас дээш буюу улсын дунджаас дээгүүр үзүүлэлттэй байна. Мэргэжилтнүүдийн ажлын байран дээр хийгддэг стандарт удирдамжийг байрлуулан, мэргэжилтнүүд 100% мэргэжлийн гарын авлагаар хангагдан, мэргэжил тус бүрээр хяналтын хуудсаар стандартыг үнэлэн ажиллаж байна.</p>
3. Эрүүл мэндийн удирдлага зохион байгуулалт хүний нөөцийн хангамжийг сайжруулах, ажлын байран дээрх дагалдан сургалтыг зохион байгуулах			

3.1	ЭМБайгууллагын хүний нөөцийн хангалт, мэдлэг ур чадварыг сайжруулах, ажлын байрны дагалдан сургалтанд хамруулах цахим мэдээллийг нэгдсэн сан бий болгох	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчийн 2016 оны 57 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндийн хүний нөөцийн хөтөлбөр”-г НБХ-ийн зөвлөснөөр 2018 оны 3 сараас эхлэн үргэлжлүүлэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна. 2018 онд анагаах ухааны их дээд сургуулийг төгсөж байгаа оюутан сурагчдад сул ажлын байр сурталчлах ажлыг Дорноговь Дархан аймгуудын Анагаах ухааны салбар сургууль, УБ-хотын АШУУИС, Сувилахуйн сургуулиуд дээр очиж 100 гаруй оюутан сурагчидтай уулзалт хийж, сул ажлын байрыг сурталчлан, 14 оюутанд орон нутагт ирж ажиллах урилга гардуулсан. 10 сарын байдлаар богино хугацааны 9 удаагийн сургалт зохион байгуулан давхардсан тоогоор 650 гаруй эмч мэргэжилтнийг хамруулсан. Сургалтын дараах үр дүнг Баян-овоо, Хүрмэн сумдад үнэлж, арга зүйгээр хангасан. УБ хотод БОЭТөвийн төрөлжсөн мэргэжлийн 28 эмч мэргэжилтнийг сургалтад хамруулсан. Мэргэжлийн зэрэг хамгаалсан эмч нараас 3, ахлах 2, тэргүүлэх 1, сувилагч нараас 3 Манлай, Ханбогд БОЭТөв хамгаалсан. БОЭТ-д нэн шаардлагатай ходоодны уян дуран, харшил, хүүхдийн нүд, тархи нугасны гэмтэл, эмэгтэйчүүдийн ЭХО, нярайн перниталь судлал, Энхийн хүслэн өрхийн эрүүл мэндийн төвийн хэвлийн ерөнхий ЭХО-ийн төрөлжсөн мэргэжлийн эмч нарыг 3 сараас эхлэн 6 сарын сургалтаар бэлтгэж, төрөлжсөн мэргэшлийн эмчийн тоог 9-өөр нэмэгдүүллээ. 2018 оны үндсэн мэргэжллээр төрийн санхүүжилтээр 9, орон нутгийн санхүүжилтээр 2 нийт 11 их эмч, нийт 13 тусгай мэргэжилтнийг резидентурын сургалтын гэрээ байгуулж, сургаж эхэлсэн. Эмчлэх, сувилах эм барих мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийн хугацаа дууссан болон багц цаг хангаагүй 27 эмч мэргэжилтэнд эрх олгуулах шалгалтыг орон нутагт явуулах хүсэлтийг хүргүүлж, 2018 оны 3 сарын 24-нд 32 эмч мэргэжилтнийг хамруулан 21 эмч мэргэжилтэн тэнцэж мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг /лиценз/-ийг олгуулсан. Улаанбаатар хотын 3-р шатлалын эмнэлгүүдийн сувилахуйн үйл ажиллагааны туршлага судлах ажлыг зохион байгуулж 10 сувилагчийг явуулж Интермэд, Гранд мед, Цус судлалын үндэсний төв Сонгино хайрхан эрүүл мэндийн төвүүдийн тэргүүн туршлага судлуулан танилцууллаа. Цогт-цэций сумын СДЭ-н их эмч НЭМ-ийн чиглэлээр Сингапур Улсад 21 хоног, БОЭТ-н эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний 7 хоногийн сургалтад Солонгос улсад хамрагдан суралцсанаар дурангийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний багтай хамтран дурангийн багаж тоног төхөөрөмжийг засварлан үйл ажиллагааг жигдрүүлж дурангийн хагалгааг үргэлжлүүлэн хийж эхэлсэн
4. Эрүүл мэндийн санхүүжилтйг үр ашигтай зарцуулна.		
4.1.	Эрүүл мэндийн санхүүжилт хөрөнгө оруулалтыг үр ашигтай зарцуулах	Аймгийн хэмжээнд улсын төсвөөс 2018 онд 11,0 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсан. Үүнээс БОЭТ-4,8 тэрбум төг, ЭМГ болон 3 СДЭмнэлэгт нийт 2,8 тэрбум төг /эмч ажилчдын 3 ба 5 жилийн тэтгэмж ЭМГ-ын төсөвт ордог/, ЗӨСТ -215,0 сая төг, сум өрхийн ЭМТ 445,7 сая төг байна. 2018 оны 1 онцлог бол хүний нөөцийн хувьд БОЭТ-д 32 орон тоог батлуулан төсөв санхүүжилт нэмэгдэж ирсэн. Улсын төсвөөс: Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн барилгыг Аглут ХХК үргэлжлүүлэн барьж, одоо 90%-ийн гүйцэтгэлтэй байна. Ханхонгор, Баяндалай сумын эрүүл мэндийн төвийн барилгын их засварыг ЭМСайдаас улсын төсвөөр эрх шилжиж ирсэн хөрөнгөөр Хүслэн

		<p>хийморь ХХК гүйцэтгэн улсын комиссоор хүлээн авч үйл ажиллагаанд оруулсан. Цогт-Овоо сумын эрүүл мэндийн төвийн барилгын их засварын ажлыг Баяжих галуут ХХК гүйцэтгэж, улсын комиссоор хүлээн авсан. Орон нутгийн төсвөөс: Шим билэг, 6-р багийн төв дээр Шим билэг эмнэлгийн салбар өрхийн эрүүл мэндийн төвийн барилгыг 8, 6-р багийн төвийн хамт барих ажлыг улсын комиссоор хүлээн авч ашиглалтанд оруулаад байна. Мандал-Овоо сумын ЭМТ-ийн барилгыг ГОХДС-ийн хөрөнгөөр барьж байгаа бөгөөд гүйцэтгэл 30%-тай.</p>
<p>5. Эрүүл мэндийн технологи</p>		
		<p>Бүсийн оношилгоо эмчилгээний төвд рентген аппарат, Гурвантэс суманд тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын техникийн нөхцөлийг гарган хүргүүлж, БОЭТ-д дижитал суурин рентген аппарат нийлүүлэх тендер зарлагдан “Евро фарм” ХХК нийлүүлэхээр гэрээ хийгдсэн. Мөн Гурвантэс суманд 200 сая төгрөгийн нэн шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг нийлүүлэхээр “ELDA” ХХК гэрээ хийсэн. БОЭТ-д яаралтай түргэн тусламжийн 1 пургон автомашин болон эмнэлгийн тоног төхөөрөмжийг орон нутгийн 60,0 сая төгрөгний төсвөөр нийлүүлэх худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж байна.</p> <p>БОЭТ-д эхний ээлжинд нэн шаардлагатай 450,0 сая төгрөгийн 29 нэр төрлийн эмнэлгийн тоног төхөөрөмж багаж хэрэгслүүдийн техникийн нөхцөлийг гаргасан. Нийт тоног төхөөрөмжийг 3н багцад хувааж тендер зарлагдсанаас 1-р багцад 2 компани, 2-р багцад 2 компани, 3-р багцад 6 компани орж ирсэн. Орон нутгийн онцлогт тохирсон 250,0 сая төгрөгийн дурангийн аппаратны иж бүрдэлийн техникийн нөхцөлийг БОЭТ-тэй хамтран гаргасан. Эмэгтэйчүүдийн дурангийн хагалгааны тендерт нийт 8 компани орж ирсэн. Үнэлгээ хийгдэж байна. 14 сум-нд эхний ээлжинд нэн шаардлагатай 105,0 сая төгрөгийн 14 нэр төрлийн 98ш эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийн жагсаалт, техникийн нөхцөлийг гаргасан. Тендер нь зарлагдан, үнэлгээ хийх ажиллагаа явагдсан. Тус тендерт “Мехатроник” ХХК шалгарч гэрээ хийгдсэн Орчин үеийн оношлогооны мобайл тоног төхөөрөмжөөр 5 сумын ЭМТөв хангахаар 6 төрлийн 30ш тоног төхөөрөмжийн жагсаалт, техникийн нөхцөлийг гаргасан. Тендер нь зарлагдан ханган нийлүүлэх компаниар “Нуган”ХХК нийлүүлж, тоног төхөөрөмжийн сургалтыг хийж, хүлээлгэн өглөө. Австралийн элчин сайдын яамнаас хөрөнгө оруулж буй төслөөр Хүрмэн, Ханбогд сумдуудыг мобайл тоног төхөөрөмжөөр хангахаар техникийн үзүүлэлтийг гарган 2 суманд зохион байгуулж эхэлсэн.</p>
<p>6. Эм зүйн тусламж үйлчилгээ</p>		
<p>6.1.</p>	<p>Эмч эмнэлгийн мэргэжилтэний эмнэл зүй эм зүйн мэдлэгийг сайжруулах</p>	<p>Олайнфарм, КРКА эмийн компаниудтай хамтран эмийн жор бичилт, антибиотикийн зохистой хэрэглээ, вирусын эсрэг эмийн зохистой хэрэглээ, зүрх судасны өвчлөлийн орчин үеийн чиг хандлага сэдвүүдээр өрхийн болон БОЭТ-ийн эмч нарт сургалт зохион байгууллаа. Мөн аймгийн ЭМ-н салбарын удирдах ажилтны зөвлөгөөний арга зүйн сургалтаар жор бичилтийг сайжруулах, нянгийн тэсвэржилтийн талаарх сүүлийн үеийн мэдээллийг хүргэж ажилласан. ЭМД-ын системийн цахим жорыг шинээр нэвтрүүлэх, цахим жор бичих арга зүйн сургалтыг ЭМДХ-тай хамтран БОЭТ, Өрх сумын 42 их эмчид Эмийн жор бичилтийн стандарт, ЭМД-ын цахим жор бичилт антибиотикийн</p>

		<p>зохистой хэрэглээ жороор олголтын сайжруулах сургалтыг аудио сургалт 1 удаа, танхимын сургалтыг 3 удаа хийсэн. ДЭМБ, ЭМЯ-с зохион байгуулсан " эмнэлзүйн эмзүйчийн туламж үйлчилгээг өргөжүүлэх нь" сэдэвт 2 өдрийн сургалтад БОЭТ-н клиник эмзүйчийг хамруулсан</p>
<p>7. Мэдээллийн технологи</p>		
		<p>Ханбогд, Цогтцэций, Гурвантэс 3 сум болон ЭМГ дээр 4 газарт телемедициныг суурилуулан, сумдуудтай цахим сургалт, зөвлөгөө, хурлыг хийж байна. Мэдээлэл технологийг системтэйгээр хөгжүүлэх төлөвлөгөөг тоног төхөөрөмж, программын шинэчлэлт, хүний нөөцийн хөгжүүлэлт гэсэн 3 зорилтын хүрээнд 9 ажил хийхээр төлөвлөсөн ба төлөвлөгөөний хэрэгжилт 77 хувьтай байна. Үүнд: ЭМБ-н интернет ашиглалт, мэдээллийн тоног төхөөрөмжийн судалгаа авч, мэдээллийн сан үүсгэсэн ба интернетийн ашиглалтыг сайжруулах чиглэлээр эмнэлгүүдэд зөвлөгөө өгөх, 3 сум, сум дундын эмнэлэг, / ГТ, ХБ ЦЦ/ ЭМГ-г телемедицинд холбох, өрх сумаас БОЭТ-д цахим дугаар олголт хийгдэх, мэдээллийн мэргэжилтнүүдийг хөгжүүлэх заалтууд амжилттай хэрэгжсэн. Харин Мэдээлэл технологийн ажилчдын зөвлөл байгуулах, цахим эрүүл мэнд төсөлийг орон нутагт хэрэгжүүлэх заалтууд нь ЭМЯам болон төслийн үйл ажиллагааны явцаас шалтгаалан хэрэгжих шатандаа явж байна. Орон нутгийн төсвийн санхүүжилтээр анхан шатны 15 ЭМБ-д компьютер, дагалдах хэрэгслээр ханган, 3 өрхийн эмнэлэгт компьютер, интернетийн төхөөрөмжийг суурьлуулж, төлбөрийг нь хариуцан, БОЭТ-ийн нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх дугаарыг авах мэдээллийн системтэй холбосон. Эхний 3 улирлын байдлаар өрх сумдаас цахимаар 1200 өвчтөн шилжүүлсний 85.4 % нь өрхөөс 14.6% нь сумаас шилжүүлсэн байна. Баяндалай, Булган, Цогт-Овоо сумдаас илүү ирүүлсэн байна.</p>
<p>8. ЭМСалбарын удирдлага зохион байгуулалт ил тод байдал</p>		
		<p>Засгийн газар, Яам, агентлаг, аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргаас гаргасан бодлого, эрх зүйн баримт бичгийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, төлөвлөгөө, арга хэмжээнд арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Эрүүл мэндийн байгууллагуудын Удирдах ажилтануудын зөвлөгөөнийг 3 сарын 5-6 нд зохион байгуулж, үйл ажиллагаанд үнэлгээ өгч, голлон анхаарах эх хүүхэд, халдварт өвчин зэрэг асуудлуудыг танилцуулж, удирдлагын чадавхийг бэхжүүлэх зөвлөмжийг өгч хамтран ажиллалаа. ЭМ-ийн 18 байгууллагад эх, хүүхдийн чиглэлээр үнэлгээ хийсэн бөгөөд Ханбогд, Булган, Ханхонгор, Номгон, Баян-Овоо, Хүрмэн сумдад багаар ажиллаж, төлөвлөлт, үйл ажиллагаанд чиглэл өгч ажиллалаа. Цагаан хад, Цогтцэций, Ханбогд, Баян-Овоо суманд 10-р сард ЭМЯ-ны багтай хамтран ажилласан. "Цагаан хад болон уул уурхайн зам дагасан эмнэлгийн тусламжийг сайжруулах" төсөл боловсруулж, /18 хуудас/ ЭМЯаманд хүргүүлж, ЗГ-т санал оруулж, 15 ортой эмнэлгийн санхүү төсвийн тооцоог гарган мөн хүргүүлээ. 11 сард төрийн албаны шалгалтын баг орон нутагт ажиллаж, төрийн захиргааны 11 ажилтан орж, ЭМГ дээр хүн нэг бүртэй ярилцлага хийж, үнэлгээ хийлээ. Төрийн албаны болон бусад хуулийг судлах "Мэдлэгт суурилсан манлайлал" аяныг өрнүүлж байна. Сумын эмнэлгийн удирдлагуудыг УБ хотод 2 хоногийн хугацаатай Сумын эмч</p>

		нарын үндэсний зөвлөгөөнд хамруулсан. Эрүүл Мэндийн газрын бүтэц, үйл ажиллагааны чиглэл баталсан аймгийн Засаг даргын 2017 оны А/1344 тоот захирамжийн дагуу 2018 онд ЭМГ-ын даргын 01 тоот тушаалаар Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтсийг 10 хүний бүрэлдэхүүнтэй шинээр зохион байгуулан ажиллаж байна.
--	--	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН: УТСХЭЛТЭС М.ЦЭНДСҮРЭН